

“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 3-р сарын 26

№ 25/03/01

Улаанбаатар хот

Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан,
болон санхүүгийн тайлан, төслийг батлах
тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэхь заалт, Тооллогын комиссын
дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ НЬ :**

1. Компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцэж баталсугай.
2. Компанийн 2025 онд хэрэгжүүлэх төсөл төлөвлөгөөг баталсугай.
3. Хурлаас баталсан төсөл, төлөвлөгөө, дүгнэлт, шийдвэрийг цаашид хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ОЮУНБОЛД

“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 3-р сарын 26

№ 25/03/02

Улаанбаатар хот

Компани ногдол ашиг хувиарлахгүй тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.6-р заалтууд, 2025 оны 3-р сарын 26 өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан ногдол ашиг хувиарлахгүй тухай шийдвэр, түүний шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсаныг мэдэгдсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ОЮУНБОЛД

“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 3-р сарын 26

№ 25/03/03

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ДҮРЭМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ,
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 17, 62 дугаар зүйлүүд, 2025 оны 3-р сарын 26 өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааны чиглэлд дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа болон андеррайтерийн үйл ажиллагааг нэмж Санхүүгийн Зохицуулах Хорооноос холбогдох тусгай зөвшөөрлийг авч компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
2. Дээрх тусгай зөвшөөрлүүдийг нэмж авч байгаатай холбогдуулан компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсүгэй.
3. Хувьцаа нэмж гаргахтай холбоотой үнэ тогтоох, холбогдох төлөвлөгөө, дүгнэлтүүдийг батлах, шаардах эрх хэрэгжүүлэх эрхийг компанийн ТУЗ-д олгосугай.
4. Хөрөнгө оруулалтын зөвлөх, дилер, гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах, андеррайтерийн эрхийг нэмж авч байгаа тул холбогдох дүрэм, журам батлах эрхийг компанийн ТУЗ-д олгосугай.
5. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.
6. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ОЮУНБОЛД

“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 3-р сарын 26

№ 25/03/04

Улаанбаатар хот

НЭМЖ ХУВЬЦАА ГАРГАХ, ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД
ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХ ЭДЛҮҮЛЭХ
ЭСЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62.1.3, 62.1.8, 38 дугаар зүйлүүд, 2025 оны 3-р сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах эрх болон Андеррайтерийн тусгай зөвшөөрөл нэмж авах гэж байгаа тул компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг таван тэрбум хүртэлх төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцаа нэмж гарган нэмэгдүүлсүгэй.
2. Нэмж хувьцаа гаргах гэж байгаатай холбоотойгоор одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ОЮУНБОЛД

“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 3-р сарын 26

№ 25/03/05

Улаанбаатар хот

ШААРДАХ ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 53, 54-р зүйлүүд, 2025 оны 3-р сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрэмд өөрчлөлт орж, улсын бүртгэлд бүртгүүлсэн тохиолдолд 2025 оны 3-р сарын 26 өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцоогүй, оролцсон ч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах эрхтэй.
2. Нэмж хувьцаа гаргах болон компанийг өөрчлөн байгуулах зөвшөөрлийг төрийн эрх бүхий байгууллага зөвшөөрсний дараа шаардах эрхийн хүрээнд нэгж хувьцааг худалдаж авах үнийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоосон үнээр эргүүлэн худалдан авахыг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ОЮУНБОЛД

“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 3-р сарын 26

№ 25/03/06

Улаанбаатар хот

ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХОЛЫН
ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76, 89, 92- р зүйлүүд, 2025 оны 3-р сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь цаашид дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах эрх, андеррайтерийн эрхийг нэмж авах гэж байгаатай холбогдуулан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, нэмэлт хувьцаа гаргах зэрэг ажилд бусадтай их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.
2. Уг хэлцэлд хяналт тавьж холбогдох эрх бүхий байгууллагууд, хувьцаа эзэмшигчдэд мэдээлж ажиллахыг Гүйцэтгэх Удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ОЮУНБОЛД

“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 3-р сарын 26

№ 25/03/07

Улаанбаатар хот

КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 18, 21-р зүйлүүд, 2025 оны 3-р сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компани нь үйл ажиллагаагаа өргөжүүлэн тусгай зөвшөөрөл нэмж авах, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангахаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх бүрт нэмэлт хувьцаа гаргах шаардлагатай байгаа нь зардал ихтэй бас зөвшөөрөл авахад маш их цаг хугацаа алдаж байгаа тул тус компанийг хуваах эсвэл тусгаарлах арга хэмжээг авч компанийг өөрчлөн байгуулсугай.
2. Компанийг өөрчлөн байгуулахтай холбоотой үнэ тогтоох, холбогдох төлөвлөгөө, дүгнэлт, хуваах, тусгаарлах баланс батлах, шаардах эрх хэрэгжүүлэх зэрэг компанийг өөрчлөн байгуулах эрхийг компанийн ТУЗ-д олгосугай.
3. Компанийн өөрчлөн байгуулагдахтай холбоотой эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ОЮУНБОЛД

“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 3-р сарын 26

№ 25/03/08

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭГ
ДАХИН АВАХ ТУХАЙ**

2025 оны 3-р сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компанийн 000026581 тоот улсын бүртгэлийн гэрчилгээний арын хуудсанд нэмэлт, өөрчлөлт, тэмдэглэгээ хийх зай үлдээгүй мөн компанийн гэрчилгээ дээд ирмэгээрээ урагдсан байх тул компанийн улсын бүртгэлийн гэрчилгээг дахин шинээр авсугай.
2. Улсын бүртгэлийн гэрчилгээг дахин авахтай холбоотой тогтоол гаргах, албан бичигт гарын үсэг зурах эрхийг ТУЗ-ийн даргад олгосугай.
3. Компанийг бүрэн төлөөлөн улсын бүртгэлийн гэрчилгээг дахин шинээр авах ажиллагааг хийж дуусгахыг ХБ79040100 регистрийн дугаартай Гомбо овогтой Оюунболдод даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ОЮУНБОЛД

“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 3-р сарын 26

№ 25/03/09

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 заалт, 2025 оны 3-р сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/02/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий зургаан хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

Ердийн гишүүн

- | | |
|-------------------|--------------|
| 1. Г.Оюунболд | /ХБ79040100/ |
| 2. А.Ариунтуяа | /УЦ88081829/ |
| 3. Б.Хосбаяр | /ОЮ89091111/ |
| 4. Р.Отгонбат | /ЧИ79061615/ |
| 5. А.Ариун-Эрдэнэ | /УШ89091524/ |
| 6. Г. Халиунаа | /ЧМ83031308/ |

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий гурван хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

- | | |
|------------------|--------------|
| 1. Ц.Сарантуяа | /Ц365062001/ |
| 2. Б.Батцэцэг | /ТГ77101021/ |
| 3. Х.Мөнгөнцэцэг | /ПД78040764/ |

3. Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ОЮУНБОЛД